



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/142

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, байгаль орчны хамгааллыг харгалзан шинэлэг аргачлалаар боловсруулсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийх, үр дүнг олон нийтэд тайлагнах үүрэг бүхий байнгын ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтад зааснаар байгуулсугай.

2.Аймгийн салбар дундын, олон талт ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд уялдсан холбогдох үйл ажиллагааны зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойн татвар гэх зэрэг бусад боломжит эх үүсвэрээс орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

4.Батлагдсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох арга хэмжээний зардлыг дараа оны орон нутгийн төсөвт тусгах саналыг боловсруулж аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

5.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийж үр дүнг улирал бүр багийн Иргэдийн Нийтийн Хурал, олон нийтэд танилцуулж байхыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

6.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад хамтран ажиллах Ажлын хэсэг байгуулах тухай 2022 оны 05 сарын 24-ны өдрийн А/280 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ






۲۵۵/۳

سعد مر نهدا وختنمبو حصن

[illegible]



Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 18-ний өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга:

Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газрын
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч,
Эдийн засаг, дэд бүтцийн хорооны дарга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн жендэрийн салбар хорооны нарийн бичгийн
дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга

Аймгийн Ерөнхий архитектор

Байгаль орчны газрын дарга

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

Сумдын Засаг дарга нар

Онон, балжийн байгалийн цогцолборт газрын

хамгаалалтын захиргааны дарга

Хэрлэн голын сав газрын захиргааны дарга

Аймгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн
нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны дарга

УДИРДАМЖ

**АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТҮҮНД
ХЯНАЛТ-МОНИТОРИНГ ХИЙХ АЖЛЫН ТУХАЙ**

НЭГ. ЗОРИЛГО

Ландшафтын нэгдмэл түвшинд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт-мониторинг хийх аймгийн салбар дундын, олон талт Ажлын хэсэг нь дараах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр хэлэлцэн байгаль орчин, газрыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг жил бүрээр төлөвлөж холбогдох байгууллага, мэргэжилтний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай санхүүжилтийг дараа оны орон нутгийн төсөвт суулгуулах саналыг боловсруулж, аймгийн Засаг даргад танилцуулах;

1.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлыг харгалзсан арга хэмжээнүүдийг сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд жендерийн мэдрэмжтэй, нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах замаар жил бүр тусган хэрэгжүүлэхэд сумдын ажлын хэсгийг мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

1.3. Жил бүрийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний салшгүй бүрдэл байдлаар боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх, үр дүнг олон нийтэд тайлагнах;

1.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын дэглэм, горимтой аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг уялдуулан хэрэгжилтийг хангах ажилд хяналт тавихад оршино.

ХОЁР. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГЛЭЛ

2.1. Дараах зохион байгуулалттайгаар ажиллана.

2.1.1. Ажлын хэсгийн улиралд 1 удаа батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу хуралдаж, үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэх, санал солилцох, цаашид

авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг Засаг даргад өгсөн чиглэлийн дагуу холбогдох албан тушаалтанд хүргүүлэх байдлаар ажиллана;

2.1.2. Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэн хурлын тэмдэглэл хөтөлж, ажлын хэсгийн даргаар баталгаажуулан аймгийн Засаг даргад танилцуулна;

2.1.3. Ажлын хэсгийн гарсан санал, зөвлөмжийг аймгийн Засаг даргад танилцуулсны дагуу хамтын шийдэл бүхий санал, зөвлөмж гаргах зааврын дагуу ажлын хэсгийн ахлагч холбогдох албан тушаалтанд чиглэл өгнө;

ГУРАВ. ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Ажлын хэсэг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, ажлын хэсгийн хийсэн ажлын тайланг улирал бүр сумын иргэд , олон нийтэд хурал, уулзалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн арга хэлбэрээр танилц